



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 18 өдөр

Дугаар А/749

Булган сум

Хатуу хог хаягдлыг технологийн дагуу  
өндөр даралтаар шатаах зуухаар хангах  
ажлыг хүлээн авах ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.21 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны Х/74 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн “Хатуу хог хаягдлыг технологийн дагуу өндөр даралтаар шатаах зуухаар хангах (Булган сум)” ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: А.Гантөмөр (Байгаль орчны газрын дарга)

Гишүүд: С.Амар (Аймгийн Засаг даргын тамгын газрын  
Хууль эрх зүйн хэлтсийн Гэрээний хэрэгжилт,  
шударга өрсөлдөөн хариуцсан мэргэжилтэн)

Д.Бямбажаргал (Булган сумын Засаг дарга)

Ц.Даваадорж (Булган сумын Тохижилт  
үйлчилгээний ангийн дарга)

Нарийн бичгийн дарга: Б.Оюун-Эрдэнэ (Байгаль орчны газрын Орчны  
бохирдол, хог хаягдал, химийн бодис, гамшгийн  
асуудал хариуцсан мэргэжилтэн)

2. Тус ажлын гүйцэтгэлийг хууль, тогтоомжид заасны дагуу техникийн тодорхойлолт, чанарын шаардлага хангасан байдлыг туршилтын шатаалт хийж шалган 2025 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор хүлээн авахыг ажлын хэсгийн ахлагч (А.Гантөмөр)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР